



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/15

Мөрөн сум

Одон медалиар шагнуулах
санал уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.19, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төр нийгэм, хөдөө аж ахуй, боловсрол, хууль зүй, соёл урлаг, шинжлэх ухаан, аж үйлдвэрийн салбарт олон жил санаачлага үр бүтээлтэй ажиллаж амжилт гаргасан иргэдийг Монгол Улсын Төрийн дээд одон медалиар шагнуулахаар уламжилсугай.

2. Төрийн дээд одон медалиар шагнуулахаар уламжлах иргэдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд нэр дэвшигчдийн тодорхойлолт, холбогдох баримт бичгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)- т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дугаар сарын 17-ний өдрийн 1/15 дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДЭЭД ОДОНГООР ШАГНУУЛАХААР ТОДОРХОЙЛОГДСОН ИРГЭДИЙН НЭРС

№	Овог	Нэр	Харьяалал	Тодорхойлж буй шагналын нэр
1	Бүүвэй	Баттогтох	Алаг-Эрдэнэ сумын 2 дугаар багийн малчин /Хөдөө аж ахуйн хүндэт профессор	Гавьяат малчин
2	Гомбожав	Намсрайдорж	Мөрөн сумын ахмад настан /Монгол Улсын алдарт уяач/	Хөдөлмөрийн гавьяаны улаан тугын одон
3	Доржханд	Сумъяасүрэн	Жаргалант сумын ЗДТГ-ын ахмад ажилтан	Алтан гадас одон

— оОо —